



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/585

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг вакцинаар  
дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2021 оны 9 дүгээр сарын 13-наас 22-ны өдрүүдэд "Томуугаас сэргийлье" уриан дор зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын 10 хоногоор эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 2-11 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйг Бүгд Найрамдах Солонгос Улсын Грийн кросс үйлдвэрийн улирлын томуугийн "GCFLU" гурван цэнт вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Заавал хийх товлолын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

4. Улирлын томуугийн эсрэг "GCFLU" гурван цэнт вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, БНСУ-ын Грийн кросс үйлдвэрийн улирлын томуугийн эсрэг "GCFLU" гурван цэнт вакциныг хэрэглэх зааврыг хоёрдугаар, Улирлын томуугийн вакцинжуулалтын хамралтын мэдээний маягтыг гуравдугаар, Улирлын томуугийн вакцин хийхэд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас авах зөвшөөрлийн хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Улирлын томуугийн эсрэг вакцинжуулалтыг коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалтын цэгээс тусад нь зохион байгуулж, зохицуулалт хийж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6. Томуу, томуу тест өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141212243



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 сарын 10-ны өдрийн 1565 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ "GCFLU" ГУРВАН ЦЭНТ ВАКЦИН,  
ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

1. АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Д/д	Эрүүл мэндийн газар	Зорилтот бүлэг			Шаардагдах дагалдах хэрэгсэл	
		Жирэмсэн эмэгтэй	2-11 насны хүүхэд	Нийт	Вакцин хүн тун	Тариур 1 мл
1	Архангай	590	9,400	9,990	9,990	9,990
2	Баян-Өлгий	920	11,560	12,480	12,480	12,480
3	Баянхонгор	600	9,120	9,720	9,720	9,720
4	Булган	330	5,690	6,020	6,020	6,020
5	Говь-Алтай	450	5,410	5,860	5,860	5,860
6	Говьсүмбэр	230	2,020	2,250	2,250	2,250
7	Дархан-Уул	780	10,390	11,170	11,170	11,170
8	Дорноговь	550	7,230	7,780	7,780	7,780
9	Дорнод	690	8,720	9,410	9,410	9,410
10	Дундговь	340	4,390	4,730	4,730	4,730
11	Завхан	480	6,850	7,330	7,330	7,330
12	Орхон	850	10,480	11,330	11,330	11,330
13	Өвөрхангай	770	11,420	12,190	12,190	12,190
14	Өмнөговь	620	7,390	8,010	8,010	8,010
15	Сүхбаатар	550	6,560	7,110	7,110	7,110
16	Сэлэнгэ	620	10,330	10,950	10,950	10,950
17	Төв	430	9,250	9,680	9,680	9,680
18	Увс	630	8,810	9,440	9,440	9,440
19	Ховд	690	9,460	10,150	10,150	10,150
20	Хөвсгөл	910	13,550	14,460	14,460	14,460
21	Хэнтий	600	7,720	8,320	8,320	8,320
<b>Аймгийн дүн</b>		<b>12,630</b>	<b>175,750</b>	<b>188,380</b>	<b>188,380</b>	<b>188,380</b>

## 2. НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Д/д	Дүүргийн эрүүл мэндийн төв	Зорилтот бүлэг			Шаардагдах дагалдах хэрэгсэл	
		Жирэмсэн эмэгтэй	2-11 насны хүүхэд	Нийт	Вакцин хүн тун	Тариур 1 мл
1	Сүхбаатар	800	14,700	15,500	15,500	15,500
2	Баянгол	1,300	25,330	26,630	26,630	26,630
3	Баянзүрх	3,000	39,790	42,790	42,790	42,790
4	Чингэлтэй	1,300	15,490	16,790	16,790	16,790
5	Сонгинохайрхан	2,200	36,370	38,570	38,570	38,570
6	Хан-Уул	1,000	22,670	23,670	23,670	23,670
7	Налайх	340	4,070	4,410	4,410	4,410
8	Багануур	500	2,830	3,330	3,330	3,330
9	Багахангай	80	450	530	530	530
<b>Нийслэлийн дүн</b>		<b>10,520</b>	<b>161,700</b>	<b>172,220</b>	<b>172,220</b>	<b>172,220</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>23,150</b>	<b>337,450</b>	<b>360,000</b>	<b>360,600</b>	<b>360,600</b>



Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 09 сарын 10-ны өдрийн 4/53  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БНСУ-ЫН ГРИЙН КРОСС ҮЙЛДВЭРИЙН УЛИРЛЫН ТОМУУГИЙН  
ЭСРЭГ "GCFLU" ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР**

Улирлын томуугийн эсрэг "GCFLU" вакцин нь 2021/2022 оны томуугийн улиралд ДЭМБ-ын зөвлөмж болгосон томуугийн вирусийн эсрэгтөрөгчийг идэвхгүйжүүлж гаргаж авсан, ДЭМБ-ын итгэмжлэл авсан вакцин юм. Вакцины найрлагад орсон томуугийн вирусийн дэд хэвшинжийн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

**Найрлага:**

Томуугийн вирусийн гурван дэд хэвшинжийг агуулсан.

А хүрээний Victoria/2570/2019IVR-215(H1N1)

А хүрээний Cambodia/e0826360/2020 IVR-224(H3N2)

В хүрээний Washington/02/2019

Нэмэлтээр тиомерсал, натрийн хлорид, калийн хлорид, динатри гидрофосфат дигитрат, калийн дигидрофосфат, тарилгын шингэн

**Савлагаа:**

Нэг хүн тун нь 0.5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар савлагдсан. Өнгөгүй, шингэн суспенз.

**Тун ба тарих арга:**

Вакциныг булчинд тарина.

- 6 сартайгаас 2 настай (35 сар буюу 2 нас 11 сар 29 хоног) хүүхдэд 0.25 мл-ээр нэг удаа тарина.
- 3 ба түүнээс дээш настай хүнд 0.5 мл-ээр нэг удаа тарина.

**Эсрэг заалт:**

- Цочмог халдвар, архаг өвчний сэдрэлийн үе;
- Вакцины найрлагад орсон бодист анафилаксийн урвал илэрч байсан өгүүлэмжтэй;
- Өндөг, тахианы гаралтай бүтээгдэхүүнд хэт мэдрэг хариу урвал өгч байсан;
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталт, саажилтын хам шинж илэрсэн;
- Мэдрэлийн үрэвслийн хамшинжийн үе;
- Харшил, багтраа өвчтэй хүн;
- Дархлал дутмагшилтай хүн;
- Дааврын эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүн;
- Хавдрын эмчилгээний цитостатик эм хэрэглэж байгаа бол.

**Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:**

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий, тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах

зэрэг хэсэг газрын урвалын шинж илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.

- Ховор тохиолдолд энцефаломиелит, анафилаксийн шок, харшлын урвал, татах, мэдрэлийн тогтолцооны ерөнхий болон хэсэг газрын үрэвсэл, амьсгалахад саадтай болох хүнд урвалууд вакцин хийлгэсний дараа 2 долоо хоногийн дотор илэрч болно. Хэрэв дээрх шинж тэмдэгүүд илэрвэл эмч, эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдээлж, эмчийн зааврын дагуу эмчилгээг хийх хэрэгтэй.

#### **Анхааруулга:**

- 1) Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна.
- 2) Томуугийн вакциныг товлолын бусад вакцинтай нэг өдөр хийж болох бөгөөд тарих талбай өөр байна.
- 3) Бусад вакцинтай 28 хоногийн завсартайгаар хийнэ.
- 4) Тарилгын стандартыг баримтлан ажиллана.
- 5) Задалсан вакциныг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
  - Вакциныг +2- +8 хэмд хадгалсан;
  - Вакцины шошгоны бичиг арилаагүй;
  - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- 6) Тарилга хийсэн хэсгийг бохирдуулахгүй байх, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд эмчид яаралтай хандахыг вакцин хийлгэж байгаа хүнд зөвлөнө.

#### **Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд**

Вакцин хийхийн өмнө жирэмсэн болон хөхүүл эмэгтэйг эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсний 14-өөс 36 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд томуугийн вакцин хийж болно.

#### **Хадгалах тээвэрлэх:**

- Вакциныг +2+8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ.
- Халууны нөлөөнд орсон эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянана.
- Хөлдөөж болохгүй.

**Хүчинтэй хугацаа:** 2022 оны 6 дугаар сар

**Үйлдвэрлэгч:** Грийн кросс корпораци, БНСУ

2021 он



Эрүүл мэндийн сайдын 2021 оны 09 сарын 10-ны өдрийн 4305 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫН МЭДЭЭ

МАЯГТ 1. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [Жирэмсэн эмэгтэй]

д/д	Эрүүл мэндийн байгууллага	Насны бүлэг			ДДУХ
		16-24 нас	25-35 нас	36-49 нас	

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 99817099 утсаар болон [tuwsanaa.uuganjargal@gmail.com](mailto:tuwsanaa.uuganjargal@gmail.com) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 2. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ [2-11 насны хүүхэд]

Д/д	Байгууллагын нэр	Хамрагдвал зохих хүүхдийн тоо	Хамрагдсан хүүхдийн тоо	Насны бүлгээр		ДДУХ
				2-5 нас	6-10 нас	

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 99817099 утсаар болон [tuwsanaa.uuganjargal@gmail.com](mailto:tuwsanaa.uuganjargal@gmail.com) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 09 сарын 10-ны өдрийн 0165  
дугаар тушаалын дөрөвдүгээр  
хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИН ХИЙХЭД ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ,  
АСРАН ХАМГААЛАГЧААС АВАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Миний хүү/охин ..... овогтой ..... нь ..... настай.

.....дүүргийн ..... хорооны .....сургууль, цэцэрлэгт суралцдаг.

Эцэг эх асран хамгаалагч Би хүүхдэдээ улирлын томуугийн вакцин хийлгэхийг зөвшөөрч байна.

Улирлын томуугийн эсрэг БНСУ-ын Грийн Кросс үйлдвэрийн "GC FLU" вакцины зааврыг уншиж, танилцсан болно.

Гарын үсэг: эцэг/ эх / асран хамгаалагч .....

Огноо: 2021 оны ..... дугаар сарын ..... өдөр

*Тайлбар:* Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулахаас өмнө энэхүү зөвшөөрлийн хуудсыг ангийн багш хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид заавал танилцуулж, гарын үсэг авсан байна. Сүүлийн нэг сарын хугацаанд товлолын болон сайн дураар томуугийн вакцинд хамрагдаагүй байх.